



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭР” ТӨХК-ИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/23/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Нацагдорж  
Утас: 261885 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ  
Утас: 261740 Цахим хаяг: [bolor-erdened@audit.gov.mn](mailto:bolor-erdened@audit.gov.mn)  
Гэрээгээр гүйцэтгэсэн Грант торнтон аудит ХХК-ийн  
Захирал: Б.Осоргарав Цахим хаяг: [info@mn.gt.com](mailto:info@mn.gt.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	16
5.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд .....	16
6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ .....	17
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
8. Аудитын илрүүлэлт .....	17
8.1 Залруулсан алдаа .....	18
8.2 Албан шаардлага .....	18
8.3 Зөвлөмж .....	19
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТТӨҮЦ	Түрээсийн тогтмол төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 071601

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хараат бус аудиторын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон зүйл

“Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ийн санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэж, толилуулсан.

Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх энэхүү заавар нь СТОУС, НББ-ийн тухай хуульд заасан нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн бөгөөд аж ахуйн нэгж байгууллагууд дотооддоо СТОУС болон Монгол Улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөж ажиллахыг шаарддаг боловч СТОУС-ын толилуулга болон тодруулгын шаардлагуудыг дагаж мөрддөггүй.

Мөн аудитлагдсан санхүүгийн тайлан нь Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааварт шаардсан бүрэн хэмжээний тодруулгыг хавсаргаагүй болно.

Компанийн санхүүгийн тайлан гарснаас аудиторын тайлан гарах хугацаанд Орос-Украины хооронд дайн гарсан нь МИАТ ТӨХК-ийн Европын чиглэлийн нислэгт шууд нөлөөлж, маршрутыг өөрчлөх, нислэг цуцлах зэрэг цаашид компанийн мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлөхүйц тодорхойгүй байдлыг үүсгэж байна.

Санхүүгийн тайлангийн 4.4-т зорилтот түвшний гүйцэтгэлтэй холбоотойгоор орлого, зардлын томоохон ажил гүйлгээний талаар тайлбарласан байгаад анхаарлаа хандуулна уу.

### **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд нийт орлогыг 220,312.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 257,732.4 сая төгрөгөөр, алдагдлыг 37,419.8 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр нийт 234,451.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 245,961.2 сая төгрөгийн зардал гарган, 11,509.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### *1. НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-ийн хэрэгжүүлэлт:*

Компани нь өөрийн эзэмшлийн агаарын хөлгийг НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-д заасны дагуу их бие, хөдөлгүүр, туслах хөдөлгүүр, хөл эд анги гэж бүрэлдэхүүнээр салган бүртгэж, бүрэлдэхүүн тус бүрийн хувьд элэгдлийн аргуудыг тогтоон шулуун шугамын болон үйл ажиллагааны аргаар элэгдүүлж байна. Их бие бүрэлдэхүүн хэсгийг 22 жилийн ашиглалтын хугацаанд, хөдөлгүүрийг нийт 80,000 цикл цаг ашиглахаас тайлант хугацаанд ногдох цикл цагийг ашиглан үйл ажиллагааны аргаар, туслах хөдөлгүүрийг нийт 20,000 бууралт, хөөрөлт хийхээс тайлант хугацаанд ногдох бууралт, хөөрөлтийн тоогоор үйл ажиллагааны аргаар тус тус элэгдүүлэн санхүүгийн тайланд элэгдлийн зардлыг хүлээн зөвшөөрч байна.

Ашигласан үзүүлэлт, удирдлагын таамаглалууд нь тохиромжгүй байж болзошгүй бөгөөд тооцооллын үр дүн материаллаг учир бид энэхүү тооцооллыг аудитын гол асуудалд оруулсан.

#### *Аудитын горим:*

Элэгдлийн тооцооллыг үнэлэхдээ дараах горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Компанийн элэгдлийн тооцоололд ашигласан орц мэдээллийн найдвартай байдлыг шалгасан,
- Ашиглалтын жил болон үйл ажиллагааны үзүүлэлтийг тодорхойлоход удирдлагын зүгээс ашигласан магадлалуудыг компанийн тооцооллын дүнтэй тулгасан

#### *2. СТОУС 16 “Түрээс”-ийн үл хүлээн зөвшөөрөлт:*

Компани нь СТОУС 16 “Түрээс”-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг түрээсийн гэрээнд түрээсийн тогтмол төлбөрийг түрээсийн хугацааны тодорхой мөчлөгт үйл ажиллагаанд суурилсан буюу ниссэн цагт ногдох байдлаар хувьсах төлбөртэй болгосон учир ТТТӨҮЦ-н тооцоололд тодорхойгүй байдал бий болсонтой холбоотойгоор санхүүгийн тайланд үл хүлээн зөвшөөрсөн байна.

#### *Аудитын горим:*

Үл хүлээн зөвшөөрөлтийг үнэлэхдээ дараах горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Үл хүлээн зөвшөөрөлтийг хийхэд ашигласан орц мэдээллийн найдвартай байдлыг шалгасан,
- Удирдлагын шийдэл нь мөн чанарын хувьд тогтмол төлбөрийг агуулсан эсэхийг нягталсан.

### **Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд тус компани нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3-д заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгож

ажлаас чөлөөлөгдсөн 11 ажилтны оронд шинээр ажилтан томилоогүй, компанийн хэмжээнд 32 сул орон тоо байгаа бөгөөд оронд нь томилгоо хийгээгүй байна.

### **Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нислэг, тээвэрлэлт зорилтын хүрээнд 1,178 удаа аялал хийхээр төлөвлөснөөс 61.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	25,442,757,870.01	15,599,719,409.00
1.1.2	Дансны авлага	14,286,547,068.30	14,229,943,181.35
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	56,114,378.86	596,971,463.93
1.1.4	Бусад авлага	2,694,043,771.93	2,318,859,286.28
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	7,961,703,841.00	-
1.1.6	Бараа материал	41,847,098,901.52	39,084,892,769.12
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,789,894,742.42	8,638,045,932.61
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дvн</b>	<b>101,078,160,574.04</b>	<b>80,468,432,042.29</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	127,260,030,685.47	118,421,015,793.93
1.2.2	Биет бус хөрөнгө	11,316,063,005.86	10,744,278,747.86
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	236,522,299,085.82	219,284,964,254.57
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дvн</b>	<b>375,098,392,777.15</b>	<b>348,450,258,796.36</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДvН</b>	<b>476,176,553,351.19</b>	<b>428,918,690,838.65</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	37,556,159,983.72	31,063,109,427.22
2.1.1.2	Цалингийн өглөг	6,744,163.25	-
2.1.1.3	Татварын өр	14,147,578,826.45	12,959,818,962.30
2.1.1.4	НДШ-ийн өглөг	3,890,086,116.34	4,551,909,971.01
2.1.1.5	Богино хугацаат зээл	52,626,433,468.67	45,298,837,201.74
2.1.1.6	Хvвний өглөг	3,468,561,965.51	479,732,697.30
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	7,335,111,621.42	7,335,111,621.42
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	14,050,941,554.76	17,185,013,313.08
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	881,754,709.99	882,679,244.72
2.1.1.12	Богино хугацаат түрээсийн өр	81,971,203,447.81	52,740,306,228.53
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дvн</b>	<b>215,934,575,857.92</b>	<b>172,496,518,667.32</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	85,295,510,484.42	73,572,015,651.29
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг	3,199,757,141.03	2,846,591,308.31
2.1.2.5	Урт хугацаат түрээсийн өр	154,479,786,207.79	149,991,160,461.61
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дvн</b>	<b>242,975,053,833.24</b>	<b>226,409,767,421.21</b>
<b>2.2</b>	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДvН</b>	<b>458,909,629,691.16</b>	<b>398,906,286,088.53</b>
<b>2.3</b>	<b>2. Эзэмшигчдийн өмч</b>		
2.3.1	Өмч : а) төрийн	5,577,283,000.00	5,577,283,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,651,158,561.09	15,651,158,561.09
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,450,986,580.22	2,376,716,050.49
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(6,412,504,481.28)	6,407,247,138.54
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дvн</b>	<b>17,266,923,660.03</b>	<b>30,012,404,750.12</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дvн</b>	<b>476,176,553,351.19</b>	<b>428,918,690,838.65</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	180,597,048,351.53	214,505,396,717.32
2	Борлуулалтын өртөг	185,820,675,903.36	217,461,674,035.62
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(5,223,627,551.83)</b>	<b>(2,956,277,318.30)</b>
4	Түрээсийн орлого	240,546,346.58	104,526,294.88
5	Хүүний орлого	1,209,871,797.83	563,646,806.85
8	Бусад орлого	2,341,276,262.22	19,241,602,350.98
9	Борлуулалт, маркетингийн зардал	116,889,346.86	309,290,372.79
10	Ерөнхий ба удирдлагын зардал	21,071,621,062.25	16,704,545,203.47
11	Санхүүгийн зардал	7,563,513,873.48	9,844,652,432.33
12	Бусад зардал	21,754,025,281.62	2,340,425,820.99
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	(5,758,621,856.93)	913,322,009.17
14	Үндсэн Хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	909,090.91	36,305,584.44
<b>17</b>	<b>Бусад ашиг(алдагдал)</b>	<b>(309,821,639.79)</b>	<b>(157,685,124.09)</b>
<b>18</b>	<b>Татвар төлөхийн Өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(58,005,517,115.22)</b>	<b>(11,453,473,225.65)</b>
<b>19</b>	<b>Орлогын татварын зардал</b>		56,364,680.69
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(58,005,517,115.22)</b>	<b>(11,509,837,906.34)</b>
<b>21</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(58,005,517,115.22)</b>	<b>(11,509,837,906.34)</b>



**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>15,651,158,561.09</b>	<b>2,338,262,860.22</b>	<b>56,876,329,104.86</b>	<b>80,443,033,526.17</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(5,283,316,470.92)	(5,283,316,470.92)
3	<b>Залруулсан Үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>15,651,158,561.09</b>	<b>2,338,262,860.22</b>	<b>51,593,012,633.94</b>	<b>75,159,717,055.25</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(58,005,517,115.22)	(58,005,517,115.22)
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	112,723,720.00	-	112,723,720.00
7	<b>2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>15,651,158,561.09</b>	<b>2,450,986,580.22</b>	<b>(6,412,504,481.28)</b>	<b>17,266,923,660.03</b>
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	24,329,589,526.16	24,329,589,526.16
9	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>15,651,158,561.09</b>	<b>2,450,986,580.22</b>	<b>17,917,085,044.88</b>	<b>41,596,513,186.19</b>
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(11,509,837,906.34)	(11,509,837,906.34)
11	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(74,270,529.73)	-	(74,270,529.73)
12	<b>2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>15,651,158,561.09</b>	<b>2,376,716,050.49</b>	<b>6,407,247,138.54</b>	<b>30,012,404,750.12</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн ( + )</b>	<b>181,531,829,669.52</b>	<b>233,805,594,291.26</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	180,741,716,615.15	223,656,996,257.41
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	272,268,884.69	12,663,257.81
1.1.3	Татаас, санхүүжилтийн орлого	56,020,880.00	-
1.1.4	Бусад мөнгөн орлого	461,823,289.68	10,135,934,776.04
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн ( - )</b>	<b>180,275,632,236.65</b>	<b>235,316,238,447.57</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	31,382,824,644.47	32,186,832,179.87
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,700,538,842.50	6,887,975,626.74
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	536,012,976.24	172,085,802.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	466,626,639.32	331,752,518.10
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	42,166,210,459.65	66,424,963,293.62
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	5,051,625,984.32	11,434,814,559.63
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,796,880,656.12	4,561,752,396.48
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,865,128,166.69	5,489,470,631.95
1.2.9	Бусад мөнгөн зарлага	90,309,783,867.34	107,826,591,439.18
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ дүн</b>	<b>1,256,197,432.87</b>	<b>(1,510,644,156.31)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн ( + )</b>	<b>27,016,603,747.84</b>	<b>9,068,843,798.54</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	3,000,000.00
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого	830,889,562.52	1,104,139,957.54
2.1.2	Хадгаламжийн бууралт	26,185,714,185.32	7,961,703,841.00
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн ( - )</b>	<b>506,607,954.00</b>	<b>294,167,174.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	506,607,954.00	294,167,174.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>26,509,995,793.84</b>	<b>8,774,676,624.54</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн ( + )</b>	<b>19,000,000,000.00</b>	<b>16,000,000,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	19,000,000,000.00	16,000,000,000.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн ( - )</b>	<b>33,611,352,256.03</b>	<b>33,189,953,221.49</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	33,611,352,256.03	33,189,953,221.49
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(14,611,352,256.03)</b>	<b>(17,189,953,221.49)</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>368,077,137.26</b>	<b>82,882,292.25</b>
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>13,522,918,107.94</b>	<b>(9,843,038,461.01)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>11,919,839,762.07</b>	<b>25,442,757,870.01</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>25,442,757,870.01</b>	<b>15,599,719,409.00</b>

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Нийт орлого</b>	<b>сая төгрөг</b>	<b>184,389.6</b>	<b>220,312.6</b>	<b>234,451.4</b>	<b>(14,138.8)</b>	<b>(6.4)</b>
1.1	Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны орлого	сая төгрөг	164,838.3	198,376.1	204,877.2	(6,501.1)	(3.3)
1.2	Үндсэн бус болон үйл ажиллагааны бус орлого	сая төгрөг	19,551.3	21,936.5	29,574.2	(7,637.7)	(34.8)
<b>2</b>	<b>Нийт зардал</b>	<b>сая төгрөг</b>	<b>242,395.1</b>	<b>257,732.4</b>	<b>245,961.2</b>	<b>11,771.2</b>	<b>4.6</b>
	<b>Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны зардал</b>	<b>сая төгрөг</b>	<b>233,687.8</b>	<b>246,935.3</b>	<b>245,463.8</b>	<b>1,471.5</b>	<b>0.6</b>
2.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	сая төгрөг	184,375.0	215,943.8	217,422.6	(1,478.8)	(0.7)
2.2	Ерөнхий удирдлага, нэмэгдэл зардал	сая төгрөг	49,312.8	30,991.5	28,041.2	2,950.3	9.5
2.2.1	- ерөнхий нэмэгдэл зардал (зардал, удирдлага)	сая төгрөг	39,473.1	17,771.5	16,102.5	1,669.0	9.4
2.2.2	- зээлийн хүү	сая төгрөг	7,329.6	10,720.0	9,577.6	1,142.4	10.7
2.2.3	- үндсэн хөрөнгийн элэгдэл (агаарын хөлгөөс бусад)	сая төгрөг	2,510.1	2,500.0	2,361.1	138.9	5.6
	<b>Үндсэн бус үйл ажиллагааны зардал</b>	<b>сая төгрөг</b>	<b>2,948.8</b>	<b>4,067.4</b>	<b>1,354.4</b>	<b>2,713.0</b>	<b>66.7</b>
<b>3</b>	<b>Үндсэн ажиллагааны ашиг (алдагдал) валютын ханшийн алдагдлыг оруулахгүйгээр</b>	<b>сая төгрөг</b>	<b>(63,764.0)</b>	<b>(44,149.5)</b>	<b>(10,596.5)</b>	<b>(33,553.0)</b>	<b>76.0</b>
3.1	Валютын ханшийн зөрүүгийн бодит олз, гарзын хэлбэлзлийн дүн	сая төгрөг	(15,597.9)	280.4	(11,819.7)	12,100.1	4,315.3
3.2	Валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз, гарзын хэлбэлзлийн дүн	сая төгрөг	9,839.4	(7,010.1)	12,733.0	(19,743.1)	281.6
<b>4</b>	<b>Татварын өмнөх ашиг/(алдагдал)</b>	<b>сая төгрөг</b>	<b>(58,005.5)</b>	<b>(37,419.8)</b>	<b>(11,453.5)</b>	<b>(25,966.3)</b>	<b>69.4</b>
5	Орлогын албан татвар	сая төгрөг	-	-	56.3	(56.3)	-
<b>6</b>	<b>Цэвэр ашиг/(алдагдал)</b>	<b>сая төгрөг</b>	<b>(58,005.5)</b>	<b>(37,419.8)</b>	<b>(11,509.8)</b>	<b>(25,910.0)</b>	<b>69.2</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналт болон удирдлагын тогтолцоог сайжруулах, хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 25-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Грант Торнтон аудит ХХК-ийн аудитор М.Батцоож, ахлах шинжээч Ш.Оюунчимэг, аудиторын туслах Ц.Баттуяа, Б.Батхишиг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Л.Болорцэцэг, чанарын хяналтын партнер Б.Дэлгэрмаа, гэрээт ажлын партнер Н.Эрдэнэцог нар хэрэгжүүлсэн.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 01/315 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байсны улмаас компанийн харилцагчдаас авах 5,881.0 сая төгрөгийн авлага төлөгдөх хугацаанаас хэтрэн найдваргүй болох эрсдэлтэй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Компанийн дотоод аудитын алба нь тайлант онд төлөвлөгөөт, удирдлагаас өгсөн үүрэг, өргөдөл гомдлын дагуу нийт 14 аудитыг хийж гүйцэтгэн 18,694.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 82 зөвлөмжийг өгч ажилласан. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 112,241.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1,122.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 246,740.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2,467.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийн жилийн эцсийн дүн нь төлөвлөлтийн үе буюу эхний хагас жилийн дүнгээс ихээхэн хэмжээний өсөлттэй байсан тул тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох нь зохистой гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн зорилго нь найдвартай, чанартай, үр өгөөжтэй, найрсаг үйлчилгээгээр Монголыг дэлхийтэй холбоход оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг олон улсын болон орон нутгийн шугамын үйлчилгээнд иргэний тогтмол болон тогтмол бус нислэг үйлдэх явдал бөгөөд үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж болно гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоот ТӨХК гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1956 оны 6 дугаар сарын 1-ний 272 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдаж, 2001 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн Төрийн өмчийн хорооны 442 дугаар тогтоолоор “Төрийн өмчит хувьцаат компани” болж өөрчлөгдсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг ТӨБЗГ-аас томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь заалттай нийцэж байна.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг нийт 7.5 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн

12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд компанийн засаглалыг сайжруулахаар ажилтнуудыг сургалтад хамруулах, төрийн байгууллагын нэгдмэл байх зарчмын дагуу компаниас бэлтгэдэг тайлан, мэдээг боловсронгуй болгох зэрэг арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн 11 ажилтны оронд шинээр ажилтан томилоогүй, компанийн хэмжээнд 32 сул орон тоо байгаа бөгөөд оронд нь томилгоо хийгээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	25,442,757.9	15,599,719.4	(9,843,038.5)
Дансны авлага	14,286,547.1	14,229,943.2	(56,603.9)
Татвар, НДШ-ийн авлага	56,114.4	596,971.5	540,857.1
Бусад авлага	2,694,043.8	2,318,859.3	(375,184.5)
Бусад санхүүгийн хөрөнгө	7,961,703.8	-	(7,961,703.8)
Бараа материал	41,847,098.9	39,084,892.8	(2,762,206.1)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,789,894.7	8,638,045.9	(151,848.8)

Үндсэн хөрөнгө	127,260,030.7	118,421,015.8	(8,839,014.9)
Биет бус хөрөнгө	11,316,063.0	10,744,278.7	(571,784.3)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	236,522,299.1	219,284,964.3	(17,237,334.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>476,176,553.4</b>	<b>428,918,690.9</b>	<b>(47,257,862.5)</b>
Богино хугацаат өр төлбөр	215,934,575.9	172,496,518.6	(43,438,057.3)
Урт хугацаат өр төлбөр	242,975,053.8	226,409,767.5	(16,565,286.3)
Эздийн өмч	17,266,923.7	30,012,404.8	12,745,481.1
<b>Нийт эх үүсвэр</b>	<b>476,176,553.4</b>	<b>428,918,690.9</b>	<b>(47,257,862.5)</b>

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 15,599.4 сая төгрөг байна. Үүнд Голомт банканд байршуулсан 800,000.0 ам.доллар буюу 2,279.0 сая төгрөгийн аккредитив данс, мөн 50,000.0 ам.доллар буюу 142.4 сая төгрөгийн баталгааны данс байна.

Тайлант онд бэлтгэн нийлүүлэгчээс хүлээн авсан бараа материал, үйлчилгээний НӨАТ-ын авлага 540.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Урт хугацаат авлагыг оруулаад авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 53,615.9 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 8,596.7 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг нөөцийн аргаар тооцдог байна. Тайлант онд 5,881.0 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулсан байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2018 онд шилжүүлсэн В737-8 “МАХ” агаарын хөлгийн нэмэлт ажилд зориулсан 799.5 сая төгрөгийн урьдчилгаа нь тус агаарын хөлөг нисэхгүй байгаатай холбоотойгоор зардлаар бүртгээгүй, урьдчилгаа дансанд бүртгэлтэй байна.

Мөн “Шинэ нисэх буудал дахь Ангарын оффисын барилга” бариулах тендер зарлан, тендерээс шалгарсан ажил гүйцэтгэгч этгээдэд олгосон 409.3 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр нь ажил зогссон шалтгаанаар урьдчилгаа дансанд бүртгэлтэй байна. Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 145.5 сая төгрөгийг зардалд хүлээн зөвшөөрсөн байна. Урьдчилгаа дансны үлдэгдэл 6,028.4 сая төгрөгийн гадаадын банкнаас авсан зээлийн эргэн төлөлтийн урьдчилгаа төлбөр байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39,084.8 сая төгрөг болж 2,762.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны худалдан авалтаас илүү зарцуулалт хийснээс шалтгаалжээ.

Тайлант онд нийт 85,587.3 сая төгрөгийн бараа материал шинээр худалдан авч, 87,881.0 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа ашиглаж орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч, 158.9 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Шинээр 300.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 1,138.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, 1,138.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг балансас баланс шилжүүлсэн, 146.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна. Тайлант онд 8,839.0 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Биет бус хөрөнгө нь 571.8 сая төгрөгийн тайлант хугацааны хорогдлын зардлаар буурсан байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгөнд 186,209.5 сая төгрөгийн ашиглах эрхтэй хөрөнгө болон 33,075.4 сая төгрөгийн урт хугацаат нисэх буудлуудын үйлчилгээний барьцаа төлбөрийг бүртгэсэн. Тайлант онд түрээсээр эзэмшиж байсан 2 агаарын хөлгийн төлбөрийн нөхцөлийг хувьсах буюу ниссэн цагт ногдох төлбөрийг төлөх болгож өөрчилсөнтэй холбоотойгоор СТОУС 16 “Түрээс”-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн 30,987.2 сая төгрөгийн

анхны өртөгтэй, 14,732.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 16,255.1 сая төгрөгийн дансны үнэтэй ашиглах эрхтэй хөрөнгийг данснаас хассан байна.

Мөн тайлант онд 3 билетийн борлуулалтын цэгийн түрээсийн байрыг 3-5 жилийн хугацаатай түрээслэн нийт 345.5 сая төгрөгийн ашиглах эрхтэй хөрөнгийг шинээр бүртгэсэн байна. Компани нь түрээсийн тооцоололд эх үүсвэрийн жинлэсэн дундаж хүү болох жилийн 15.5 хувийн үр ашигт хүүг ашиглан түрээсийн тогтмол төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолсон байна.

Урт хугацаат барьцааны авлагын хувьд 989.3 төгрөгийн барьцааг нэмж байршуулсан ба 2,519.2 сая төгрөгийн барьцааг буцаан төлсөнтэй холбоотойгоор 1,529.9 сая төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд зорчигч, агаарын тээврийн өр, ААНОАТ-ын өр төлбөр, түрээсийн богино хугацаат өр төлбөр, банкнаас авсан зээлийн дараагийн тайлант онд төлөгдөх хэсэг болон түүний хүүгийн өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2018-2020 онд 2013 онд шинээр агаарын хөлгийг худалдан авахаар гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эргэн төлөлтөд зарцуулахаар үүссэн 73,572.0 сая төгрөгийн зээл, СТОУС 16 “Түрээс”-ийн бүртгэлийн хүлээн зөвшөөрөлттэй холбоотойгоор үүссэн 149,991.1 сая төгрөгийн урт хугацаат агаарын хөлгийн барьцаа 2,846.5 сая төгрөг байна.

Урт хугацаат зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор харилцагч банкуудтай зээлийн үндсэн төлөлтийг хойшлуулах гэрээ хийснээс шалтгаалсан бөгөөд энэ нь эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд компанийн төлбөрийн чадварыг сайжруулах, мөн ирээдүйд их хэмжээний, хугацааны хувьд давтамж ойрхон өр төлбөрүүдийг төлөх үүргийг бий болгох үр дагавартай байна.

Шалгагдагч байгууллага Хөгжлийн банкнаас 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр нийт 1,275.7 сая иенийн зээлийг агаарын хөлгийн паркийг шинэчлэх зориулалттай авч, зээлийг 2013 онд шинээр агаарын хөлгийг худалдан авахаар гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эргэн төлөлтөд зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт 628.0 сая иен, зээлийн үлдэгдэл 647.7 сая иен байна. Хөгжлийн банкнаас авсан зээл төлөгдөхгүй байгаа нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр агаарын тээврийн салбарт үүссэн хүнд нөхцөл байдлаас шалтгаалан МИАТ ТӨХК нь зээлийн үндсэн төлбөрийг 2022 оны 3 дугаар сарын 25-наас эхлэн төлөхөөр хүсэлт гаргасан бөгөөд хүсэлтийн дагуу зээлийн үндсэн төлбөрийг хойшлуулсан байна. Энэ нь компанийн төлбөрийн чадварыг өсгөх, улмаар санхүүгийн хүндрэлийг давах эерэг үр дагавартай байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг аккрузал сууриар хүлээн зөвшөөрч, түүхэн өртгөөр хэмжин толилуулахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Өмнөх онтой харьцуулахад нийт зардал 3,566.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад нислэгийн тоо ихсэн улмаар борлуулалтын өртөг өссөнөөс шалтгаалжээ.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт агаарын хөлгийн шатахууны зардал, газрын үйлчилгээний төлбөр, сэлбэг хэрэгслийн зардал зэрэг зардлуудыг хамруулсан байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 612 дугаар тогтоолоор Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 220,312.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 257,732.4 сая төгрөгөөр, 37,419.8 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 21,932.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 234,451.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 245,961.2 сая төгрөгийн зардал гарган, 11,509.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 234,451.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 14,138.8 сая төгрөг буюу 6.4 хувиар давсанд дараах үйл явдлууд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

1. Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 370 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагад төлөх 9,273.2 сая төгрөгийн, Засгийн газрын нөөц сангийн эх үүсвэрээс авсан зээлийн алдангийн үлдэгдэл 989.7 сая төгрөгийн өглөгийг тус тус чөлөөлөх шийдвэрийн дагуу эдгээр өр төлбөрийг орлогоор бүртгэсэн,
2. Компанийн түрээсээр эзэмшиж байсан агаарын хөлгийг 2019 оны 3 дугаар сард АНУ-ын Холбооны нисэхийн удирдах газар болон дэлхийн бусад улс орнуудын иргэний нисэхийн удирдах газруудаас тодорхойгүй хугацаагаар зогсоож, газардуулах шийдвэрийг гаргасантай холбоотойгоор Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-д үүссэн санхүүгийн хохирлыг шийдвэрлэж өгөх талаар түрээслүүлэгч компанид хүсэлт гаргасны үр дүнд 3.3 сая ам.долларын нөхөн төлбөрийг 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдөр 9,401.9 сая төгрөгийг шилжүүлснийг орлогоор бүртгэсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 245,961.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 11,771.2 сая төгрөг буюу 4.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь Компанийн түрээсээр эзэмшиж байсан агаарын хөлгийг 2019 оны 3 дугаар сард АНУ-ын Холбооны нисэхийн удирдах газар болон дэлхийн бусад улс орнуудын иргэний нисэхийн удирдах газруудаас тодорхойгүй хугацаагаар зогсоож, газардуулах шийдвэрийг гаргасантай холбоотойгоор СТОУС 16 “Түрээс”-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн ашиглах эрхтэй хөрөнгийн 10,812.5 сая төгрөгийн элэгдлийн зардал, 7,449.5 сая төгрөгийн хүүгийн зардлыг буцаасан гүйлгээ нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 11,509.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 25,910.0 сая төгрөгөөр дутуу байгаа нь төлөвлөсөн орлогыг илүү, зардлыг хэмнэж ажилласантай холбоотой байна.

Тайлант онд 168.0 сая төгрөгийн түрээсийн төлбөрийн 40 хувь болох 68.4 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэхээр өглөг үүсгэсэн боловч ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 37 дугаар хурлаар “Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахлын улмаас 2020 оноос олон улсын агаарын тээврийн хуваарьт нислэгийг тодорхойгүй хугацаагаар зогсоосноос шалтгаалан МИАТ ТӨХК өр төлбөрөө төлж чадахгүй хэмжээнд хүрч, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдалд орсон тул 2021 оны түрээсийн гэрээний дагуу төсөвт төвлөрүүлэх 68.4 сая төгрөгийн орлогыг компанид үлдээхийг дэвжив” гэсэн хурлын шийдвэрийг үндэслэн ТӨБЗГ-т төвлөрүүлэх байсан түрээсийн орлогыг тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

## 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь тайлант онд нийт 17,864,522.1 мянган төгрөгийн 6 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бүх мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан байна.

## 5.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд

Компани нь тайлант онд 4,309,400.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ нисэх буудал дахь Ангарын оффисын барилга” бариулах тендерийг 2020 оны 1 дүгээр сараас 2021 оны 1 дүгээр сарын хооронд 2 удаа зарласан бөгөөд сүүлийн тендерт ганц оролцогч Далу ХХК материалаа ирүүлсэн бөгөөд тус тендерийн материалыг тендерийн үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27.3, 27.4-т заасан шаардлагуудыг хангаагүй тул тендерийг амжилтгүй болсон гэж дүгнэсэн боловч тус оролцогчтой шууд худалдан авах аргын дагуу гэрээ байгуулсан байна.

Гэрээ байгуулахад саналын хуудаст санал өгөх эрх бүхий албан тушаалтан нь “Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.6-г үндэслэн нэгдмэл сонирхолтой этгээд тул татгалзаж байна, Компанийн 2021 оны худалдан авалтын төлөвлөгөөний 2.6-д уг ажлын тайлбар хэсэгт санхүүжилт шийдвэрлэсэн тохиолдолд гэснийг үндэслэн санхүүжилт шийдэгдээгүй тул гэрээ байгуулах боломжгүй” гэсэн үндэслэлээр гэрээ байгуулахыг татгалзсан боловч гэрээг байгуулсан байна.

Мөн Далу ХХК нь 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан 21/46 тоот барилгын “Ажил гүйцэтгэх гэрээ”-нд ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 8 дугаар сарын 15-ны дотор бүрэн гүйцэд чанартай хийж, Улсын комисст хүлээлгэн өгөх гэрээний үүргийг биелүүлээгүй бөгөөд МИАТ ТӨХК нь 409.4 сая төгрөгийн урьдчилгаа өгсөн боловч ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий нөхцөлийн 46-д “гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.2-т "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана." гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хууль, тогтоомж, заавар журмыг мөрдөж ажилласан эсэхийг шалгуулахаар Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжтой нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар 3,209.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,989.4 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 1,339.6 сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж өгснөөс, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	8	6,989,421.0	1	-	7	6,989,421.0	-
Зөвлөмж	10	1,339,604.1	10	1,339,604.1	-	-	100
Нийт дүн	18	8,329,025.1	11	1,339,604.1	7	6,989,421.0	50

Өмнөх аудитаар өгсөн 10 харилцагчаас авах нийт 6,969,421.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах 6 албан шаардлага өгснөөс тайлант онд бүрэн төлөгдөөгүй хэдий ч хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлэх, эрүүгийн цагдаагийн газарт эрэн сурвалжлуулах хүсэлт өгөх зэргээр компанийн зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Тиймээс эдгээр авлагуудыг бүрэн барагдуулах хүртэл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Мөн ТӨБЗГ-ын 2019 оны 229 дүгээр тогтоолын дагуу МИАТ ТӨХК-ийн 2018 оны цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт ногдол ашгийн орлого төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн боловч төвлөрүүлээгүй тул ТӨБЗГ-т 2019 оны аудитаар орлого төлүүлэх акт, 2020 оны аудитаар актыг хэрэгжүүлэх албан шаардлагыг хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд ногдол ашгийн орлого төвлөрүүлэх актыг төлөх хуваарь гарган төлж барагдуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Компани нь санхүүгийн байдлын тайлангийн эздийн өмчийн бусад хэсэгт ТӨБЗГ-ын шийдвэрээр балансаас балансад шилжүүлсэн хөрөнгө болон шилжиж ирсэн хөрөнгийг бүртгэдэг бөгөөд компанийн хуучин НБББББ-т засгийн газрын буцалтгүй тусламжийг хэрхэн бүртгэх талаар тодорхой заагаагүй байсан тул 2022 оны 1 сарын 1-нээс эхлэн мөрдөх НБББББ-т энэхүү ажил гүйлгээний бүртгэлийг хэрхэн хийх тухай заасан эсэхийг шалган, бүртгэл зохистой эсэхийг нарийвчлан судалбал зохистой байна.

Мөн ТӨБЗГ-н тогтоол, шийдвэрийн дагуу тэтгэмж, урамшуулал, нэмэгдэл цалин олгосон асуудал гарвал нарийвчлан судлабал зохистой гэж үзлээ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,430.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, аудитын явцад 4,266.1 сая төгрөгийг залруулж, 162.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2.1 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгч, нэг алдаа зөрчлийг Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 164.4 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 2,467.4 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 4,266.1 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-ын 27-т "Аж ахуйн нэгж нь мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг ашиглан бэлтгэнэ" гэсэн заалтын дагуу 80.0 сая төгрөгийн зардлыг аккруэл сууриар бүртгэн залруулсан;
- НББОУС 12 "Орлогын албан татвар"-ын 34-т "Ашиглагдаагүй татварын алдагдал ба ашиглагдаагүй татварын хөнгөлөлтийг ашиглаж болохоор ирээдүйн татвар ногдох орлого олох нилээд их магадлалтай хэмжээгээр уг ашиглагдаагүй татварын алдагдал ба ашиглагдаагүй татварын хөнгөлөлтийн ирээдүйд шилжүүлэлтийн хувьд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө." гэж заасны дагуу 3,259.4 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн;
- Компанийн НБББББ-ийн 15.3-т "...Дансны авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар ТУЗ-ийн шийдвэрээр хөрөнгийн нийт дансны үнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна" гэсэн заалтын дагуу 926.7 сая төгрөгийн авлагын залруулгыг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй гэсэн үндэслэлээр буцаан залруулга хийсэн.

### 8.2 Албан шаардлага

1. Гүйцэтгэх захирлын 2018 оны Б/645 тоот тушаалаар халагдсан ажилтныг 2 удаагийн иргэний хэргийн шүүхээр "үндэслэлгүй халсныг тогтоон ажилгүй байх хугацааны нийт 85.5 сая төгрөгийн нөхөн олговор олгох"-оор шийдвэрлэсэн байна. Энэхүү шийдвэрийг биелүүлэхдээ одоогоор компанийн хөрөнгөөс 49.1 сая төгрөгийг олгосон, 36.4 сая төгрөгийг ажилтанд олгохоор санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэх.

2. Компанийн нэрийг олон улсын болон дотоодын спортын уралдаан тэмцээнд сурталчлах, алдаршуулах зорилгоор Үндэсний болон чөлөөт бөхийн 4 тамирчинд сар бүр нийт 8.5 сая төгрөгийн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 8.8 сая төгрөг нийт 76.8 сая төгрөгийг компаниас төлөхөөр гэрээ байгуулан тайлант жилийн цалингийн зардалд төсөвлөн тайлагнасан нь нийгэм эдийн засгийн хүнд нөхцөлд тэвчиж болох зардлыг хэмнэлтгүй, үргүй зардал гаргасан байна.

Монгол улсын засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй,

Шийдвэрлэсэн: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь гүйцэтгэх удирдлагыг ажлаас чөлөөлөхдөө МИАТ ТӨХК болон түүний дэргэдэх бие даасан Үйлдвэрчний эвлэлийн хороо хооронд байгуулсан "Хамтын гэрээ"-ний дагуу тэтгэмжийг олгоогүй байна.

Энэ нь Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1-т "Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг хууль дүрэм журамд нийцүүлэн тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Тушаал, шийдвэрийн үндэслэлийг хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв гаргах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх Албан шаардлага өгөх

### **8.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Дотоод хяналтын тогтолцоотой холбоотой асуудал**

##### 1.1 Илрүүлэлт:

Төлөөлөгчийн газруудад олгосон санхүүжилтийг нотлох баримт руу тулган шалгахад Бээжингийн төлөөлөгчийн газрын санхүүгийн үйл ажиллагааны баримтууд 2021 оны 7 дугаар сараас хойш ирээгүй байгаа нь бодит гүйцэтгэлийг цаг тухайд нь хянах боломжгүй нөхцөл байдлыг бий болгож байна. Мөн

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна", 4.1.5-т "өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж

Төлөөлөгчийн газарт тавих дотоод хяналтыг сайжруулан үр дүнтэй, дотоод хяналтын тогтолцоог бий болгох

##### 1.2 Илрүүлэлт:

Компанийн дотоод аудитын нэгжтэй бөгөөд тус нэгж нь гүйцэтгэх удирдлагын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж ажлаа тайлагнаж байгаа нь дотоод аудитын нэгжийн хараат бус байдал алдагдсан, бие даасан байдлыг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Компанийн засаглалын кодексийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т "Дотоод аудитын газар байгууллагын бүхий л түвшинг хамарсан хяналт шалгалт явуулах, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын тогтолцоонд мониторинг хийх чиг үүрэгтэй байх бөгөөд гүйцэтгэх удирдлагаас хараат бус бие даасан, өндөр мэргэшсэн ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байна." гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

##### Өгсөн зөвлөмж

Гүйцэтгэх удирдлагаас хараат бус дотоод аудитын алба, хэлтэстэй болж, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах.

#### **2. Засаглалтай холбоотой асуудал**

##### 2.1 Илрүүлэлт:

Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг бүрэн хөтөлдөггүй учир ашиг, сонирхлын зөрчилтэй хэлцлийг илрүүлэхгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 89.2-д "Дор дурдсан этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтан болон хувьцааны хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ:

89.2.1.тэдгээрийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн;

89.2.2.тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү;

89.2.3.тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талууд" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг компанийн тухай хуульд заасан бүх оролцогчдыг хамруулан бэлтгэн, өөрчлөлтийг тухай бүрд нь оруулж байх

#### 2.2 Илрүүлэлт:

Компани нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн иж бүрэн тодруулгатай санхүүгийн тайланг бэлтгэдэггүй, Сангийн сайдын 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг олон нийтэд ил болгож байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.1 "Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1."Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

8.1.1.санхүүгийн байдлын тайлан;

8.1.2.орлогын дэлгэрэнгүй тайлан;

8.1.3.өмчийн өөрчлөлтийн тайлан;

8.1.4.мөнгөн гүйлгээний тайлан;

8.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга" гэж заасанд нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэж олон нийтэд ил тод болгох

### **3. Балансын данстай холбоотой асуудал**

#### 3.1 Илрүүлэлт:

МИАТ ТӨХК, ажилтан, үйлдвэрчний эвлэлийн 3 талт "Хамтын гэрээ"-ний дагуу ажилтнуудаа өндөр насны тэтгэвэрт гарах үед тэтгэмж, тэтгэвэр олгоно гэж заасан боловч тус үүсмэл үүрэг хариуцлагын нөөц өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, тайлагнаагүй байна.

Энэ нь НББОУС 19 "Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж"-ийн 51-т "Ажилтнууд тайлант үеийн туршид аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тухайн ААН нь тогтоосон шимтгэлийн хөтөлбөрт уг үйлчилгээний хариу болгон төлөх шимтгэлийн өглөгийг хүлээн зөвшөөрнө." гэсэн заалтыг зөрчиж байна.

#### Өгсөн зөвлөмж:

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн нөөцийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, хэмжилтийн дүнг тодорхойлох үндэслэлтэй суурьтай болох

### **4. Цалингийн зардалтай холбоотой асуудал**

#### 4.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалингаас 2.1 сая төгрөгийн ХХОАТ-ыг илүү суутгаж, тооцооллын алдаа гаргасан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна. .... 7.1.4-д "төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого", 14-д "энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Цалингийн тооцооллыг нягтлан шалгаж, шинэчлэгдсэн хуулийг тухай бүрд нь мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
2	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх захирлын 2018 оны Б/645 тоот тушаалаар халагдсан ажилтныг 2 удаагийн иргэний хэргийн шүүхээр “үндэслэлгүй халсныг тогтоон ажилгүй байх хугацааны нийт 85,503 мянган төгрөгийн нөхөн олговор олгох”-оор шийдвэрлэсэн байна. Энэхүү шийдвэрийг биелүүлэхдээ одоогоор компанийн хөрөнгөөс 49,140 мянган төгрөгийг олгосон, 36,363 мянган төгрөгийг ажилтнуудад олгохоор санхүүгийн тайланд тайлагнасан байна.	Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй Албан шаардлага хүргүүлэв	1	85,503.5					1	85,503.5				
3	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Компанийн нэрийг олон улсын болон дотоодын спортын уралдаан тэмцээнд сурталчлах, алдаршуулах зорилгоор Үндэсний болон чөлөөт бөхийн 4 тамирчинд сар бүр нийт 8,500.0 мянган төгрөгийн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 8,813.0 мянган төгрөг нийт 76,813.0 мянган төгрөгийг компаниас төлөхөөр гэрээ байгуулан тайлант жилийн цалингийн зардалд төсөвлөн	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, Албан шаардлага хүргүүлэв	1	76,813.0					1	76,813.0				



			тайлагнасан нь Нийгэм эдийн засгийн хүнд нөхцөлд тэвчиж болох зардлыг хэмнэлтгүй, үргүй зардал гаргасан байна.															
	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Төлөөлөн Удирдах Зөвлөл нь гүйцэтгэх удирдлагыг ажлаас чөлөөлөхдөө МИАТ ТӨХК болон түүний дэргэдэх бие даасан Үйлдвэрчний эвлэлийн хороо хооронд байгуулсан "Хамтын гэрээ"-ний дагуу тэтгэмжийг олгоогүй байна.	Тушаал, шийдвэрийн үндэслэлийг хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв тодорхойлох, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх Албан шаардлага өгөх	1	-					1	-						
4	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Төлөөлөгчийн газруудад олгосон санхүүжилтийг нотлох баримт руу тулган шалгахад Бээжингийн төлөөлөгчийн газрын санхүүгийн үйл ажиллагааны баримтууд 2021 оны 7 дугаар сараас хойш ирээгүй байгаа нь бодит гүйцэтгэлийг цаг тухайд нь хянах боломжгүй нөхцөл байдлыг бий болгож байна. Мөн Төлөөлөгчийн газрын билетийн орлогыг тухай бүр тушаагаагүйгээс 6,917.3 мянган төгрөгийн он дамжсан авлага үүсэж шүүх, хяналтын байгууллагад хандсан байна.	Эдгээр сул талуудыг илрүүлэн компанийн цаашдын үйл ажиллагааг дэмжих зорилгоор дотоод хяналтын үр дүнтэй, бат бөх дотоод хяналтын тогтолцоог бий болгох зөвлөмж өгөв	1	-												1
5	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Компанийн дотоод аудитын нэгжтэй бөгөөд тус нэгж нь гүйцэтгэх удирдлагын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг, гүйцэтгэх удирдлагад ажлаа тайлагнаж байна.	Гүйцэтгэх удирдлагаас хараат бус дотоод аудитын алба, хэлтэстэй болох зөвлөмж өгөв	1	-												1
6	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	МИАТ ТӨХК, ажилтан, үйлдвэрчний эвлэлийн 3 талт "Хамтын гэрээ"-р	Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн нөөцийг санхүүгийн тайланд	1	-												1

			хүлээсэн үүсмэл үүрэг хариуцлагын нөөц өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, тайлагнаагүй байна.	хүлээн зөвшөөрч, хэмжилтийн дүнг тодорхойлох үндэслэлтэй суурьтай болох зөвлөмж өгөв																
7	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалингаас 2,126.2 мянган төгрөгийн ХХОАТ-г илүү суутгаж, тооцооллын алдаа гаргасан байна.	Цалингийн тооцооллыг нягтлан шалгаж, шинэчлэгдсэн хуулийг тухай бүрдт нь мөрдөж ажиллах зөвлөмж өгөв	1	2,126.1													1	2,126.1
8	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг бүрэн хөтөлдөггүй.	Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг компанийн тухай хуульд заасан бүх оролцогчдыг хамруулан бэлтгэн, өөрчлөлтийг тухай бүрд нь оруулж байх зөвлөмж өгөв	1	-													1	-
9	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Компани нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн иж бүрэн тодруулгатай санхүүгийн тайланг бэлтгэдэггүй.	СТОУС-д нийцсэн тайланг бэлтгэн олон нийтэд ил тод болгох зөвлөмж өгөв	1	-													1	-
10	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Өмнөх аудитаар авлага барагдуулах 6 албан шаардлагыг биелэлт хангалтгүй байна.	Авлага барагдаж дуустал арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх зөвлөмж өгөв	1	-													1	-
	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Өмнөх аудитаар тогтоосон ногдол ашгийн орлого төвлөрүүлэх төлбөрийн актын биелэлт хангалтгүй байна.	Актыг төлөх хуваарь гарган төлж барагдуулах зөвлөмж өгөв	1	-													1	-
11	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-н 27-т "Аж ахуйн нэгж нь мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг ашиглан бэлтгэнэ" гэсэн заалтын дагуу 80,000.0 мянган төгрөгийн зардлыг аккруэл сууриар бүртгэн залруулсан.	Санхүүгийн тайланд залруулав	1	80,000.0	1	80,000.0												

12	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	НББОУС 12 "Орлогын албан татвар"-ын 34-т заасны дагуу 3,259,343.6 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн.	Санхүүгийн тайланд залруулав	1	3,259,343.6	1	3,259,343.6									
13	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	НБББББ-т заасны дагуу холбогдох тушаал шийдвэргүйгээр данснаас хассан 926,733.4 мянган төгрөгийн авлагын залруулгыг буцаасан .	Санхүүгийн тайланд залруулав	1	926,733.4	1	926,733.4									
<b>НИЙТ ДҮН</b>					14	4,430,519.6	3	4,266,077.0	-	-	3	162,316.5	-	-	8	2,126.1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал																	
1	МИАТ ТӨХК	АХГ-2022/23/НА-СТА-ТӨА	Компани нь тайлант онд 4,309.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Шинэ нисэх буудал дахь Ангарын оффисын барилга" бариулах тендерийг сонгон шалгаруулахдаа хууль тогтоомжийг зөрчсөн	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх	1	-											
<b>ДҮН</b>					1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>					15	4,430,519.6	3	4,266,077.0	-	-	3	162,316.5	-	-	8	2,126.1	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 513/2015 0458

Улаанбаатар хот

АХГ- 2022/23/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу МИАТ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь гүйцэтгэх удирдлагыг ажлаас чөлөөлөхдөө МИАТ ТӨХК болон түүний дэргэдэх бие даасан Үйлдвэрчний эвлэлийн хороо хооронд байгуулсан "Хамтын гэрээ"-ний дагуу тэтгэмжийг олгоогүй байна.

Энэ нь Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1 "Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг хууль дүрэм журамд нийцүүлэн тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тушаал, шийдвэрийн үндэслэлийг хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв гаргаж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга С.Батболдод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

С.НАЦАГДОРЖ

ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.БОЛОРЦЭЦЭГ

9006109  
9019120396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 510/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/03/чА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу МИАТ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт нийт 85,503,560.00 төгрөгийг олгохоор шийдвэрлэснийг компанийн хөрөнгөөс 49,139,764.00 төгрөгийг олгож, 36,363,796.00 төгрөгийг олгохоор санхүүгийн тайланд тайлагнасан байна.


Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халагдсан ажилтанд олгосон 85,503,560.00 /Наян таван сая таван зуун гурван мянга таван зуун жаран/ төгрөгийн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг авч, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга М.Энхболдод, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Л.БОЛОРЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 511/АО150458

Улаанбаатар хот

АХГ-0022/23/МА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу МИАТ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн нэрийг олон улсын болон дотоодын спортын уралдаан тэмцээнд сурталчлах, алдаршуулах зорилгоор Үндэсний болон чөлөөт бөхийн 4 тамирчинд сар бүр нийт 8,500,000.00 төгрөгийн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 8,813,000.00 төгрөг нийт 76,813,000.00 төгрөгийг компаниас төлөхөөр гэрээ байгуулан, тайлант жилийн цалингийн зардалд төсөвлөн тайлагнаж, нийгэм, эдийн засгийн хүнд нөхцөлд тэвчиж болох зардлыг хэмнэлгүй, үргүй зардал гаргасан байна.


Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мөнхтамир, ерөнхий нягтлан бодогч Д.Мөнхтулга нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Л.БОЛОРЦЭЦЭГ







